

2014 он 12 сар 03 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хаалттай хувьцаат компани болж өөрчлөх,
дүрмийн шинэчлэн найруулсан хувилбарыг батлах тухай

Ард Санхүүгийн Нэгдэл (АСН) ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2014 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг Хаалттай хувьцаат компани болгож өөрчлөн зохион байгуулахыг дэмжиж, доорх нөхцлөөр шийдвэрлэсүгэй.
 - 1.1. Ард Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн 22,752,700 ширхэг зарласан хувьцааг Ард Санхүүгийн Нэгдэл Хаалттай Хувьцаат Компанийн 22,752,700 ширхэг зарласан хувьцаанд хөрвүүлсүгэй.
 - 1.2. Ард Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа хувьцааг компани өөрчлөгдөх өдрөөр Хаалттай Хувьцаат Компанийн хувьцаанд хөрвүүлсүгэй.
2. Хаалттай хувьцаат компани болж өөрчлөн зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан Компанийн дүрмийн шинэчлэн найруулсан хувилбарыг Хавсралтаар баталсугай.
3. Компанийн хэлбэрийг өөрчилж, Хаалттай Хувьцаат Компани болохтой холбоотойгоор холбогдох хууль тогтоомж, журам зааварт заасан шаардлага, нөхцөлийг ханган, ҮЦТТХТөвд бүртгүүлэх, СЗХ-нд мэдэгдэж зөвшөөрөл авахыг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



ЖАНЧИВЫН ОЮУНГЭРЭЛ

